

2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ
ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Шинжээчээр хамтран ажиллах урилга

Үндэсний аудитын газар нь “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүн”-д шинжилгээ хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулах, аудитын багт мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг санал ирүүлэхийг урьж байна..

Шинжээч нь ЯАГ-АД/22-018 дугаар ажлын даалгаврын дагуу аудитад дээрх хуулийн хэрэгжилт, цар тахлын эсрэг хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эдийн засгийн арга хэмжээ, цар тахалтай холбоотой гадаад зээл, тусламжийн дүн, зарцуулалт, төрийн болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг хамруулж, гэрээт ажлыг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэргэжлийн, нотлох баримтаар баталгаажсан үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна.

Ажлын даалгаварт дурдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Шинжээчийн тайланд судалгааны явцад илэрсэн асуудлууд, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Тайлан болон холбогдох судалгаа, тооцоолол нотлох ажлын баримтыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

Мэдээллээ ирүүлж буй шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт, санхүүгийн дэлгэрэнгүй санал, урилгад хавсаргасан маягтаар нэмэлт мэдээлэл ирүүлэхээс гадна дараах мэдээллийг хавсарган ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/.

Шинжээчид тавигдах шаардлага:

Шинжээч нь аудитын баг болон Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллаж, аудитын үйл ажиллагаанд оролцохдоо аудитад хамрагдах байгууллагуудтай ашиг сонирхлын зөрчилгүй, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн дараах шаардлагыг хангасан хувь хүн, баг, хуулийн этгээд байна.

Дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;

- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд судалгаа хийх, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргах чадамжтай байх;
- Халдвар судлал, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, дүн шинжилгээ хийж, таамаглал дэвшүүлэх чадвартай байх;
- Шинжээч нь шалгагдагч байгууллагад ажиллаж байгаагүй, тэдний ашиг сонирхол, нөлөөлөлд автахгүй байх.

Ажлын даалгаврыг татан авч танилцана уу.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдээллээ 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 10 минутын дотор дараах цахим хаягаар tsend-ayushn@audit.gov.mn, info@audit.gov.mn/ pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр, 409 тоот өрөө. Үндэсний Аудитын газар, Утас: 26 35 33.
www.audit.mn.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны
6 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дүгээр
тушаалын 7 дугаар хавсралт

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ  Я.САРАНСҮХ

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮНД ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ДҮГНЭЛТ
ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 04 дугаар сарын
14-ний өдөр

Дугаар ~~УАС-АД~~
22-018

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО: Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүнд шинжилгээ хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулах, аудитын багт мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд энэхүү ажлын зорилт оршино.

Эхлэх хугацаа: 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдөр
Дуусах хугацаа: 2022 оны 6 дугаар сарын 2-ны өдөр
Байршил: Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын төлөвлөгөө, сэдэв батлах тухай” 2022 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар олгосон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэнэ.

Аудитад бодлогын болон нарийн мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах, эм эмнэлгийн хэрэгсэл, бусад асуудлаар шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, цар тахлын эсрэг хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эдийн засгийн арга хэмжээ, цар тахалтай холбоотой гадаад зээл, тусламжийн дүн, зарцуулалт, төрийн болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг хамруулна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэргэжлийн, нотлох баримтаар баталгаажсан үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-д заасны үндэслэнэ.	“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүнд аудит хийж, Монгол Улсын 2020-2021 оны Ковид-19-ын нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх	/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.4 заалт
2	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.11 заалт
3	Цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, сайжруулсан түлш, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.12 заалт
4	Эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.13 заалт
5	Коронавирусын халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.21 заалт
6	Цар тахлын үед арга хэмжээ авахдаа хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.22 заалт
7	Цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 7.1.23 заалт
8	Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 9.1 заалт
9	Коронавируст халдварыг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх шинэ арга, аргачлалыг олон улсын, эсхүл үндэсний эмнэл зүйн туршилт, зөвлөмжид үндэслэн оношилгоо, эмчилгээнд хэрэглэх ажилд шинжилгээ хийх, дүгнэлт гаргах			/Ковид-19/-ын тухай хуулийн 9.15 заалт
10	Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүнд санал дүгнэлт, зөвлөмж өгөх		Санал дүгнэлт, зөвлөмж өгөх	Дээрх хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан холбогдох байгууллагын шийдвэр, бусад баримт бичиг

Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажлын хүрээнд шаардлагатай нэмэлт ажил гүйцэтгэх

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль цаашид /Ковид-19/-ын тухай хууль гэх

Гэрээт ажилд тавигдах шаардлага, хэмжээ, формат

- Үе шатны тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай “single”, үсгийн фонт “Arial”, үсгийн хэмжээ 12/ байх бөгөөд гэрээ ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, ном, хэвлэл, холбогдох бусад мэдээлэл зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Шинжээч нь ажлын даалгаварт дурдсан ажлын чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Шинжээчийн тайланд судалгааны явцад илэрсэн асуудлууд, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Тайлан болон холбогдох судалгаа, тооцоолол нотлох ажлын баримтыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь аудитын баг болон Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллаж, аудитын үйл ажиллагаанд оролцохдоо аудитад хамрагдах байгууллагуудтай ашиг сонирхлын зөрчилгүй, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн дараах шаардлагыг хангасан хувь хүн, баг, хуулийн этгээд байна.

Дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд судалгаа хийх, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргах чадамжтай байх;
- Халдвар судлал, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, дүн шинжилгээ хийж, таамаглал дэвшүүлэх чадвартай байх;
- Шинжээч нь шалгагдагч байгууллагад ажиллаж байгаагүй, тэдний ашиг сонирхол, нөлөөлөлд автахгүй байх;

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал /үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө/ санхүүгийн дэлгэрэнгүй санал/ тусад нь дугтуйлсан байх/;


Дээрх шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбарыг ирүүлнэ.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, гэрээнд заасан хуваарийн дагуу олгоно.

ХЯНАСАН: АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Я.САМБУУНЯМ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР  Б.БАТТОГТОХ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЦЭРЭНДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР


Б. БУЯНХШИГ
Т. ТӨМӨРБААТАР

Д.ЦЭГМИДДОРЖ
Б.БУЯНХШИГ
Т.ТӨМӨРБААТАР